

**ЧИН УЛСЫН ҮЕИЙН ХОРЧИН ЗҮҮН ГАРЫН ХОЙД ХОШУУНЫ ВАН
ГҮНГИЙН УДАМ УГСААНЫ БИЧГИЙГ ЭМХЭТГЭН СУДЛАХ НЬ¹**

УЛААН

Товч агуулга. Өгүүлэлд, XVIII зууны монгол түүхэн бичиг, Чин улсын албанаас найруулсан түүхэн бичиг, монгол ван гүнгийн гэрийн үеийн бичмэл зэрэг түүхэн сурвалжид тэмдэглэсэн Хорчин зүүн гарын хойд хошууны ван гүнгийн үе сүлжээсийг танилцуулан, харьцуулж судалсны үндсэн дээр, эдгээр түүхэн сурвалжийн давуу талыг нотолж, алдаа мадагтай талыг нөхвөрлөн, ташаа зүйлсийг нь залруулж, Мянган Дархан ноёноос доош арван дөрөвдүгээр үе Хишиг гүн хүртэлх үе сүлжлийг эмхэтгэн шүүж, эмхлэн тэмдэглэсэн болно. Үүний дагуу, Зангилан ноёны тухай ба Сэнгэринчиний төрсөн эцгийн удам гарал, үе залгамж, үрчилсэн эцгийн үр хүүхдийн байдал зэрэг асуудлыг судлан тодруулав.

Түлхүүр үг. *Хорчин зүүн гаран хойд хошуу, ван гүн, үе залгамж*

Чин улсын үед, Гадаад Монголын эл хошууны ван гүнгүүд гэрийн үеийн бичмэл найруулах нь монголчуудын уламжлалт заншлын үргэлжлэл мөртөө тухайн үеийн улс төрийн шаардлага болжээ. Чин улсаас Гадаад Монголын эл хошууны хошуу засаг, ван гүн, тайж, тавнанд үе залгамжлах дүрэм хэрэгжүүлж, тэд нар эрхбиш нарийн тэмдэглэсэн гэрийн үеийн бичмэл бичиж бэлтгэн, дээш Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яаманд мэдүүлж, үе залгамжлах үед хянаж үзүүлнэ. Анх таван жилд нэг удаа засаж дээш мэдүүлж байснаас арван жилд нэг удаа болжээ (1). Үүнээс эхлэн бүрэн төгөлдөр гэр үеийн бичмэл найруулах дүрэм болж бүрэлдэж, хувь хүний ажиллагаа байснаас албан чанартай ажиллагаа болж, эл хошуу яамнаас эрхбиш гүйцэтгэх албан явдал болжээ. Энэ нь түүхэн материалын уламжлал ба хуримтлуулгад туйлын их ашигтай явдал болно. Чин улс мөхсөний дараа, Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яам хийгээд эл хошууны яаманд хадгалж байсан монгол ван, гүнгийн гэрийн үеийн бичмэл гээгдэн орхигдож эхэлжээ. Цаашлан XX зууны дунд үеэс эхлэн хувь хүний хадгалж байсан гэрийн үеийн бичмэл ч цөөрчээ. “Дундад улсын эртний

¹ Тус өгүүлэл бол 2019 онд Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны тусгай төрлийн суурь мөнгөний төсөл “Чин улсын үеийн Нон Хорчин зүүн гарын гурван хошууны ван гүнгийн удам угсааны бичгийн эмхэтгэл судлал” (Зөвшөөрөгдсөн дугаар: 2019ZJD016)-ийн бүтээл болно.

монгол ном бичгийн ерөнхий гарчиг”-ийн хамаа бүхий тэмдэглэлийг үндэслэвэл, одоо улсын дотоодод нийт хоёр зуу гаруй монгол эл хошууны засаг ван гүнгийн гэрийн үеийн бичмэл бий (2). Дийлэнх нь бүр Чин улсын сүүлч буюу Иргэн улсын үед бичигдсэн албан чанартай гэрийн үеийн бичмэл болно. Чин улсын эхэн үед бичигдсэн хувь хүний гэрийн үеийн бичмэлийн зарим нь нэг мөсөн устаж, одоо үлдсэн нь тун цөөн болжээ. Иймээс, түүхийн хувьсалт, цаг үеийн хувиралтад үрэгдэж гээгдсэнгүй, үлдэж ирсэн түүх соёлын өв болох гэрийн үеийн бичмэлүүдээ цуглуулан эмхэтгэж, нягтлан судлах нь түүхч бидний үүрэг юм.

Хорчин зүүн гарын хойд хошуу бол Чин улсын үед байгуулагдсан Жирэмийн чуулганы Нон арван хошууны нэг болно. Тэнгэрийн Сэцэний гуравдугаар он (1629)-д засаг томилж, засаг хошуу байгуулав (3). Хавт Хасарын арван тавдугаар үеийн хойч Бодидара Зоргол ноёны хоёрдугаар хөвгүүн Намсай Дурал ноёны хоёрдугаар хөвгүүн Мянган Дархан ноёны өмчид суурилж байгуулагджээ. Мянган Дархан ноён Хорчин ноёдын дотроос хамгийн тэргүүнд Манжийн Нурхачтай харилцаж, ураг садан бололцон, хэдэн зуун жил үргэлжилсэн Манж-Монголын ургийн харилцааны эхлэлийг үүсгэв. Хамгийн анхны хошуу засаг Донхор Илдэчээс арван нэгдүгээр удаад хошуу засаг болсон Сэнгэринчин Тайпин Тяньго-ийн тариачны бослогыг дарангуйлахад чухал гавьяа байгуулсан учир Түгээмэл Элбэгтийн тавдугаар он (1855)-д зэрэг дэвшин Бодлогот чин ванд өргөмжлөгдсөнөөс, нутгийн монголчууд тус хошууг бас “Бүв вангийн хошуу” гэж, Нон арван хошууны дотор дөрөвдүгээр хошуугаар тооцдог. Мөн Чин улсаас эфү заахад бэлтгэсэн арван гурван монгол хошууны нэг болно.

Хорчин зүүн гарын хойд хошууны ван гүнгийн угсаа залгамжлалын тухай XVIII зууны монгол түүхэн бичгүүд, Чин улсын албанаас найруулсан түүхэн бичиг, одоо олдож байгаа гэрийн үеийн бичмэл зэрэгт тэмдэглэгдэж бүхий агуулга нь тэгшгүй, харилцан зөрөөтэй, адил бус тэмдэглэл бас олон оршиж байна. Доор дээрх түүхэн сурвалжийг цуглуулан эмхэтгэж, харьцуулан судалж, тус хошууны ван гүнгийн үе сүлжлийг эмхлэн тэмдэглэсэн байна.

Нэг. Хорчин зүүн гарын хойд хошууны ван гүнгийн угсаа залгамжлалд холбогдох түүхэн сурвалжийн танилцуулга хийгээд судлал

Нэг. Монгол түүхэн сурвалж бичиг

1. *Алтан хүрдэн мянган хигээст*. Монгол түүхэн сурвалж бичгүүдийн дотор хамгийн анх хошуугаар нэгж болгон монголын эл хошууны ван гүнгийн угсаа удмыг тэмдэглэсэн нь 1739 онд Жаруудын Ширээт гүүш Дарма-гийн туурвисан “Алтан хүрдэн мянган хигээст” болно. Тус бичиг нийт зургаан дэвтрээс бүрэлджээ. Тавдугаар дэвтэр нь Чингис хааны дөрвөн дүүгийн үр хойчсын ноёлсон эл хошууны ван гүнгийн удмын бичиг болно. Үүнд, Хорчин зүүн гарын хойд хошууны ван гүнгийн угсааг Мянган Дархан ноёноос Чимэддорж ван хүртэл 8 үе, нийт 41 хүнийг тэмдэглэжээ. Донхор Илдэчийн үр хойчийг Зангилан

ноёноос Чимэддорж ван хүртэл тэмдэглэсэн 7 жүн ван, 1 туслагч тайж, 1 эфү, бэйс зэрэг нь бусад түүхэн бичиг “*Зарлигаар Тогтоосон Гадаад Монгол Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир*” зэрэгт тэмдэглэсэнтэй нийцнэ. Донхор Илдэчээс гадна Мянган Дархан ноёны бусад 12 хөвгүүний үр хойч (үүний дотор 3 хөвгүүн нь үргүй)-ийг доош хоёр үе хүртэл тэмдэглэсэн байна. Энэ нь туйлын ховор нандин түүхэн материал болно. Учир нь Донхор Илдэчийн үр хойчис Хорчин зүүн гарын хойд хошууг ноёлноос Чин улсын албанаас найруулсан түүхэн бичгүүд, тэрчлэн одоо олдож бүхий тус хошууны ван гүнгийн гэрийн үеийн бичмэлд ч зөвхөн Донхор Илдэчийн нэгэн салааны удам угсааг тэмдэглэж буй. Үүнээс бид гүүш Дарма-гийн ашигласан түүхэн материалын үнэ цэнэ, түүний түүх бичлэгийн хэв намбыг мэдэж болно. Засан залруулах зүйл гэвэл, тус бичигт зохиогч гүүш Дарма-гаас Мянган Дархан ноёны үр, Хорчин зүүн гарын өмнөд хошууг захирсан ноёд хэмээж, Эр Хонхор Бинтийн үр Хорчин зүүн гарын хойд хошууг захирсан гэжээ (4). Үүнд, Мянган Дархан ноён, Эр Хонгор Бинт хоёрын үрийн захирсан хошууг харилцан сольж, эндүүрсэн байна.

2. “*Алтан эрих*” болон “*Болор эрих*”. “*Алтан хүрдэн мянган хигээст*”-ээс хожуу үед зохиогдсон Урадын баруун гарын хошууны Мэргэн хийдийн гэгээн Лувсамдамбийжалцаны “*Алтан эрих*” ба Баарин баруун хошууны Рашпунцагийн “*Болор эрих*”-д тэмдэглэсэн Нон арван хошууны ван гүнгийн удам угсаа нь үндсэндээ “*Алтан хүрдэн мянган хигээст*” бичгээс эрэлтэй. Ялангуяа Мянган Дархан ноёны үр хойчсын тухай тэмдэглэл нь дээрх гурван монгол түүхэн бичигт үндсэндээ адил. Рашпунцагаас гүүш Дарма-гийн Мянган Дархан ноён, Эр Хонгор Бинт хоёрын үрийн захирсан хошууг харилцан сольсон эндүүг дагалдан ташаарчээ (5).

Хоёр. Чин улсын албанаас найруулсан түүхэн бичиг

Чин улсын албанаас найруулсан түүхэн бичгийн дотор, Монголын аймгуудын үүсэл эрэл, ноёдын удам угсааг тэмдэглэснээр төлөөлөх чанартай нь “*Зарлигаар Тогтоосон Гадаад Монгол Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир*” (“Илтгэл шастир” хэмээн товчилъё) болно. Чин улсын хаадын “*Магад хууль*”, “*Чингийн түүхэн ноорог*” зэргийн тэмдэглэл нь үндсэндээ “*Илтгэл шастир*”-тай адил.

“Илтгэл шастир”-ын “Илтгэл”-ийн хэсэгт ван, бэйл, бэйс, гүн, засгуудын анх өргөмжлөгдсөн, залгамжлагдсан удаа дараа үйл ажиллагаа ба нас барсан жил зэрэг агуулгыг жагсаасан байна. “Шастир”-ын хэсэгт Монголын олон аймгуудын үүсэл, эрэлт, ноёдыг үр удам, Чин улсад орж өгсөн цаг үе буюу байлдан дагуулагдсан цаг үеийг тодорхойлж, тэдгээр аймгуудын Чин улсад ван, бэйл, бэйс, гүн, засаг өргөмжлөгдсөн хүмүүст шастир бичиж тэд нарын нэг насны үйл ажиллагаа, хэргэм зэрэг залгамжилсан цаг үе, хөвгүүд ач нарын удам угсааг тэмдэглэжээ.

Эдгээр бичгүүдийн бүхий л агуулгаас авч үзвэл, Чин улсын улс төрийн үүрэг зорилготой авцалдуулж, монгол ноёдын гавьяа зүтгэл, зэрэг

залгамжилсан ноёдыг тэмдэглээд, зэрэг хэргэм, нэр төргүй хүмүүсийг үндсэндээ тэмдэглэсэнгүй. Иймээс удам угсааны бичгийн хувьд, агуулгын талаар өрөөсгөл болсноор барахгүй, эндүү ташаа зүйл зонхи харагдана. Хорчин зүүн гарын хойд хошууны жишээн дээр өгүүлбэл,

1. Зангилан. Зангилан бол зүүн гарын Хорчин хошууны хоёрдугаар үеийн хошуу засаг болно. “Илтгэл шастир” (6) зэрэгт Зангиланыг Донхор Илдэчийн ахмад хөвгүүн хэмээн тэмдэглэж буй. Бид “Гүймөнх Тасхар ноёны гэрийн үеийн бичмэл” ба “Бодлогот чин ван Амарлингуйн хошууны гэрийн үеийн зураг”-ийн тэмдэглэлээс үзвэл, Донхор Илдэчээс хоёр хөвгүүнтэй, даруй Мада Дархан ноён, Зангилан хоёр болно. Донхор Илдэчийн ахмад хөвгүүн Мада Дархан ноён үргүй (эсхүл эрт нөгчсөн магад)-гээс болж, хоёрдугаар хөвгүүн Зангилан нь эцгийнхээ зэргийг залгамжилсан бололтой.

2. Зангилан ноёны хөвгүүдийн тухай. Зангилан ноёны хөвгүүдийн тухай дээрх бичгүүдэд зөвхөн түүний ахмад хөвгүүн засгийн төрийн жүн ван Бунтарийг л тэмдэглэжээ. “Бодлогот чин ван Амарлингуйн хошууны гэрийн үеийн зураг”-ийг үндэслэвэл, Зангилан ноён Бунтар, туслагч тайж Молонтой, тайж Лайса гэх гурван хөвгүүнтэй байжээ.

3. Сэнгэринчиний үрчилсэн Содномдоржийн тухай. “Илтгэл шастир”, “Чингийн түүхэн ноорог” (Qing-ün teüken noorag) зэрэгт бүр Содномдоржийг Балжирын ахмад хөвгүүн гэж, үргүй хэмээн тэмдэглэжээ (8). Гэвч “Бодлогот чин ван Амарлингуйн хошууны гэрийн үеийн зураг”-т Сэвдэнбалжир (Балжир)-аас Цэнгүнжав, Цэвээн, Яшжамц, Содномдорж гэх дөрвөн хөвгүүнтэй. Цэнгүнжав, Цэвээн, Яшжамцыг бүр зэрэг олгоогүй, үргүй гэж тэмдэглэжээ. Бас нэг нь, Содномдорж өөртөө үргүй биш, түүнд зарлигаар нэр шагнагдсан Уртхишигт хэмээх хөвгүүнтэй, харамсалтай нь Уртхишигт үргүй (эсхүл эрт нөгчсөн магад).

Иймэрхүү жишээ олон бий. Иймээс “Илтгэл шастир” зэрэг албан бичгүүдэд ван, гүн, бэйл, бэйс нарын зэрэг хэргэм залгамжилсан байдлыг нарийн тэмдэглэсэн боловч, тэдний үр хойчсын тухай тэмдэглэснийг нь бусад түүхэн сурвалжтай харьцуулж үзвэл зохино.

Гурав. Гэрийн үеийн бичмэл

Зохиогчид олдоод байгаа Хорчин зүүн гарын хойд хошууны ван, гүнд холбогдох гэрийн үеийн бичмэл нь доорх хоёр зүйл болно.

1. “Гүймөнх Тасхар ноёны гэрийн үеийн бичмэл”. Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд хадгалагдаж байна. Чин улсын сүүлчээр бичигджээ. Тус бичмэлд Гүймөнх Тасхар ноёны ахмад хөвгүүн Бодидара Зоргол ноён ба хоёрдугаар хөвгүүн Намудара Галзуу ноёны хойчсын зэрэг тушаал залгамжилсан тухай тэмдэглэжээ. Бүгд 15 үеийн 282 хүнийг тэмдэглэжээ. Үүний дотроос Хорчин зүүн гарын хойд хошууны ван гүнгийн үе сүлжилийг шүүж эмхэтгэвэл, Мянган Дархан баатар ноёноос хамгийн сүүлчийн Бодлогот чин ван Амарлингуй хүртэл тэмдэглэжээ.

Мянган Дархан баатар, ахмад хөвгүүн Улсын түшээ гүн Донхор Илдэч ноён, Донхор Илдэчийн хоёрдугаар хөвгүүн засгийн төрийн жүн ван Зангилан, Зангиланы ахмад хөвгүүн засгийн төрийн жүн ван Бунтар, Бунтарийн ахмад хөвгүүн төрийн жүн ван Жагар, Жагарын ахмад хөвгүүн засгийн төрийн жүн ван Тайбу, Тайбугийн хоёрдугаар хөвгүүн засгийн төрийн жүн ван Лувсанраш, тавдугаар хөвгүүн дэд зэрэг тайж Танжин, Лувсанрашийн хоёрдугаар хөвгүүн Чан чин менд явсан засаг төрийн жүн ван Сэвдэнбалжир, Танжины аравдугаар хөвгүүн дөтгөөр зэргийн тайж Цэвээнжав, Сэвдэнбалжирийн дөрөвдүгээр хөвгүүн шадар сайд явсан, чин вангийн зэрэг засгийн төрийн жүн ван хошой эфү Содномдорж, Цэвээнжавын дөрөвдүгээр хөвгүүн зарлигаар нэхэж бэйс өргөмжилсөн Бэхи, Содномдовжийн зарлигаар тэжээсэн хөвгүүн шадар сайд засгийн хошоо бодлогот чин ван шударга баатар Сэнгэринчин, Бэхийн ахмад хөвгүүн улсад туслагч гүн Намхайринчин, Сэнгэринчиний ахмад хөвгүүн шадар сайд явсан засгийн хошоо бодлогот чин ван хошой эфү Буяннэмэх, Намхайринчиний ахмад хөвгүүн Чан чин менд явсан улсад туслагч Буянбаригч, Буяннэмэхийн ахмад хөвгүүн шадарт явсан чин ван өргөмжилсөн Нарс, хоёрдугаар хөвгүүн шадарт явсан төрийн бэйл Үндэс, гуравдугаар хөвгүүн шадар сайд улсад туслагч гүн Бодис, дөрөвдүгээр хөвгүүн дэд зэргийн тайж Улиас, Буянбаригчийн хоёрдугаар хөвгүүн улсад туслагч гүн Насан-Арвижих, Нарсын хойч дөрөвдүгээр хошууг хошоо Бодлогот чин ван Амарлингуй захирмуй. Энэ хошуу дотор төрийн бэйл нэг, улсад туслагч хоёр.

Тус гэрийн үеийн бичмэлд, Мянган Дархан баатрын ахмад хөвгүүн Донхор Илдэчийн үр хойчийн чин ван, жүн ван, бэйл, бэйс, гүн залгамжлагчдыг голчлон тэмдэглэснээс гадна, онц зарим тэмдэглэл нь туйлын их баримтын үнэ өртөгтэй юм.

Эн тэргүүнд, тус гэрийн үеийн бичмэл нь дараачийн тайлбарлах гэж байгаа “Бодлогот чин ван Амарлингуйн гэрийн үеийн зураг”-ын хамаа бүхий тэмдэглэлийн үнэн бодит чанарыг гэрчилж тайлна. Учир нь зарим тэмдэглэл нь тус хоёр гэрийн үеийн бичмэлд л тэмдэглэгдэж байгаа юм. Яриангүй одоо олдож байгаа хэвчээ дотор жишээлбэл, Зангилан ноёны тухай, тус гэрийн үеийн бичмэлд Зангилан ноёныг Донхор Илдэчийн хоёрдугаар хөвгүүн гэжээ. “Бодлогот чин ван Амарлингуйн гэрийн үеийн зураг”-т Донхор Илдэч хоёр хөвгүүнтэй, Мада Дархан ноён үргүй, засгийн төрийн жүн ван Зангилан гэжээ.

Тайбу жүн вангийн тавдугаар хөвгүүн Дэнжингийн үр хойчсыг зөвхөн тус хоёр гэрийн үеийн бичмэлд тэмдэглэж байна. Тэмдэглэл үнэн бодит байхыг харилцан гэрчилж чадна.

2. Мянган Дархан Баатар ноёны ахмад хөвгүүн улсын түшээ гүн Донхор Илдэч ноёноос уламжилсан эдүгээгийн засаг “Бодлогот чин ван Амарлингуйн хошууны гэрийн үеийн зураг”, дөхөмчлөөд “Бодлогот чин ван Амарлингуйн хошууны гэрийн үеийн зураг”, Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд хадгалагдаж байгаа “Жирэмийн чуулган ба Ар Хорчин аймгийн гэрийн үеийн бичмэл”-ээс сонгон авчээ. Тус гэрийн үеийн бичмэлд

Жирэмийн чуулганы Нон арван хошуу ба Зуу-Удын чуулганы Ар Хорчин хошууны ван гүнгийн үе сүлжил, зэрэг, хэргэм залгамжилсан байдлыг зураг хүснэгтээр тэмдэглэжээ. Бадаргуулт төрийн гучин дөрөвдүгээр он (1908)-ы 9 сарын 25-ы өдөр тэмдэглэн хадгалжээ. Үүний дотор Хорчин зүүн гарын хойд хошууны байдлаас үзвэл, Мянган Дархан ноёноос доош нийт 13 үеийн 78 хүнийг тэмдэглэжээ. Үүнд, ноён цолтой 15 хүн, засаг төрийн жүн ван 9 хүн, Бодлогот чин ван 4 хүн, улсын түшээ хүн 2 хүн, улсад туслагч хүн 5 хүн, хошууны бэйс 2 хүн, төрийн бэйл 2 хүн, тэргүүн тайж 3 хүн, дэд тайж 4 хүн, туслагч дэд тайж 1 хүн, туслагч тайж 1 хүн, гутгаар тайж 5 хүн, дөтгөөр тайж 7 хүн, тайж 6 хүн, зэрэг олгоогүй мөртлөө үргүй гэж тодотгосон нь 6 хүн, үргүй 10 хүн, зэрэг тушаалгүй 10 хүн, шадарт явсан тогосын отго шагнагдсан 5 хүн, Чан чин менд явсан тогосын отго шагнагдсан 1 хүн, тогосын отго шагнагдсан 2 хүн, Чан чин менд явсан 1 хүн, тойн 2 хүн, хутагт лам 1 хүн, хошой эфү 4 хүн, зарлигаар нэр шагнагдсан 1 хүн, зарлигаар тэжээгдсэн 2 хүн.

Тус гэрийн үеийн бичмэл бол Хорчин зүүн гарын хойд хошууны түүх, соёлыг судлахад дутагдаж болшгүй түүхийн гэрч материал болно. Энд дээрх монгол түүхэн сурвалж ба манж, хятад албан бичигт тэмдэглээгүй хүн олон илэрч, ялангуяа тайж зэрэгтэй буюу зэрэг хэргэмгүй хүмүүсийг олон тэмдэглэжээ. Тэдгээр нэр төргүй, зэрэг хэргэмгүй энгийн гишүүдийг тус гэрийн үеийн бичмэлээс гадна, бусад түүхэн сурвалжид үндсэндээ тэмдэглэсэнгүй. Иймэрхүү ховор чухаг түүхэн баримт нь бусад түүхэн сурвалжийн хүрэлцэхгүй талыг нөхвөрлөж болно. Гэвч тус гэрийн үеийн бичмэлд мөн хүрэлцэхгүй тал бий. Даруй үе үеийн үр хойчийг бүр хүснэгтээр тэмдэглэж, хэн хэний хөвгүүн гэж тодотгож бичсэнгүй учир бусад түүхэн сурвалжтай харьцуулан үзэхгүй бол дөхөмгүй зүйл олон тохиолдоно. Доорх хүснэгт бол зохиогчоос “Бодлогот чин ван Амарлингуйн хошууны гэрийн үеийн зураг”-аас буулгасан хэсэг агуулга болно.

Хүснэгт 1

Засгийн төрийн жүн ван Равдан, засаг төрийн жүн ван Лувсанраш, тайж Дамар, тайж Амарлингуй, тайж Даржаа		
Хошууны бэйс хошой эфү Цэвээндорж	Шадарт явсан тогосын отго шагнагдсан чуулганы тэргүүн, засгийн төрийн Жиюүн ван хошой эфү зургаан зэрэг тэмдэглэсэн Чимэддорж үргүй, Чан чин менд тогосын отго шагнагдсан засгийн төрийн жүн ван Сэвдэнбалжир	Дэд тайж Аюурбунь, дөтгөөр тайж Бишээ, Балсан, Сацаг, Минжүүр, дөтгөөр тайж Бадрангуй, Бух үргүй, дөтгөөр тайж Юндэнсамбуу, дөтгөөр тайж Саянранбуу

Гэгээгийн хөвгүүн Чан чин менд явсан улсын түшээ гүн Сономцэрэн, гутгаар тайж Цэвээнноров, гутгаар тайж Лаваан, дөтгөөр тайж Гэмбэлдорж	Зэрэг олгоогүй Цэнгүүнжав үргүй, зэрэг олгоогүй Цэвээн үргүй, шадарт явсан тогосын отго шагнагдсан чин ван зэрэг засгийн төрийн жүн ван хошой эфү хоёр зэрэг нэмсэн долоон зэрэг тэмдэглэсэн Содномдовж	Зэрэг олгоогүй Баяжих үргүй, дөтгөөр тайж, тойн банди, зарлигаар нэхэж бэйс өргөмжилсөн хоёр зэрэг тэмдэглэсэн Бэхи
Улсад туслагч гүн Бүрэн, зэрэг олгоогүй, Зүрх үргүй	Ахмад хөвгүүн, зарлигаар нэр шагнагдсан Уртхишигт үргүй, зарлигаар тэжээсэн шадар сайд засгийн жүн ван Сэнгэринчин ...	Дөтгөөр зэргийн тайж хоёр зэрэг нэмсэн Намхайринчин, хоёрдугаар дүү Сэнгэринчинийг Содномдовжид үр болгожээ, тогосын отго шагнагдсан нэг зэрэг нэмсэн Чүнгэринчин, тойн Чүнгэгараг

Дээрх мэт Равдан жүн вангаас Сэнгэринчин ван хүртэлх дөрвөн үеийн хүмүүсийг бүр хүснэгтээр илтгэж, үүний доторх бусад түүхэн сурвалжид илэрсэнгүй, зэрэг хэргэмгүй хүмүүсийн хоорондох төрлийн харьцааг тодлох нарийн шинжлэл хэрэглэсэн. Тус хүснэгтийн гуравдугаар голд мөрийн гурван жижиг хүснэгтийн тэмдэглэсэн хүмүүсийн тухай “Гүймөнх Тасхар ноёны гэрийн үеийн бичмэл”-д тэмдэглэсэн “Тайбугийн тавдугаар хөвгүүн дэд зэрэг тайж жанжин, жанжны аравдугаар хөвгүүн дөтгөөр зэргийн тайж Цэвээнжав, Цэвээнжавын дөрөвдүгээр хөвгүүн зарлигаар нэхэж бэйс өргөмжилсөн Бэхи, Бэхийн ахмад хөвгүүн улсад туслагч гүн Намхайринчин” хэмээн тэмдэглэсэнтэй уялдуулж үзвэл, эл үеийн хоорондох харьцаа илэрхий болно. Үүнээс бид Сэнгэринчин вангийн төрсөн эцгийн гарал угсааг мэдэж болно. Тус хоёр гэрийн үеийн бичмэлийн тэмдэглэл нь бидэнд туйлын ховор нандин түүхэн баримтыг хангаж өгсөн юм. Чин улсын албанаас найруулсан түүхэн бичгүүдэд Сэнгэринчиний төрсөн гэрийн гарал эрэл, үе залгамжийг тэмдэглэсэнгүй, Сэнгэринчинийг зөвхөн Содномдовж жүн вангийн үрчилсэн хөвгүүн (8) буюу холын төрлийн үеэлд хөвгүүн хэмээжээ (9). Зөвхөн “Чингийн түүхэн ноорог”-т Сэнгэринчиний төрсөн эцэг нь Бэхи, дөтгөөр тайж, бэйс нэхэж өргөмжилжээ хэмээн тэмдэглэжээ (10). Үүнийг дагалдан, эрдэм шинжилгээнийхэн ч Сэнгэринчиний төрсөн аав нь чухам Содномдоржийн төрлийн хэний үр хойч болохыг хараахан судлаагүй байсаар байна (11). Дурьдууштай нь, Цюань Шан абугай 1984 оноос эхлэн Хорчин зүүн гарын хойд хошууны хошуун ойллого найруулах ажилд оролцон, тус хошууны тухай их хэмжээний түүхэн материал цуглуулж, бас тус хошууны түүх соёлыг мэддэг настайчууд ба Сэнгэринчиний хойч үеийг сурвалжлан “Сэнгэринчиний нэгэн нас” гэсэн өгүүллийг бичсэн байна. Тус өгүүлэлд “Сэнгэринчиний эцэг нь Бөхдэлгэр, их авга нь Бөхтөмөр лам байж, тайж гаралтай, Содномдовж Жиюүн вангийн холын төрөл, таван үе салсан

төрөл болно” (12) хэмээж, мөн гарал эрлийг нь тодорхой гаргаж чадсангүй. Тэгвэл бид дээрх хоёр гэрийн үеийн бичмэлийн тэмдэглэлийг үндэслэвэл доорх мэт: Ахмад хөвгүүн Равдан жүн ван → Сэвдэнбалжир → Содномдовж → Тайбу жүн ван → тавдугаар хөвгүүн Танжин тайж → Цэвээнжав → Бэхи → Сэнгэринчин. Үүнд Сэнгэринчиний төрсөн эцгийн гарал ба үрчилсэн эцэг хоёулангийнх нь харьцаа тов тодорхой болжээ.

Хоёр. Хорчин зүүн гарын хойд хошууны ван гүнгийн үе сүлжлийн бичиг

Хорчин зүүн гарын хойд хошууны ван гүнгийн удам угсааны тухай өмнөх судалгааны байдлаас үзвэл, өмнөх нь бүр Чин улсын албанаас найруулсан бичиг “*Илтгэл шастир*”, “*Чингийн магад хууль*” зэргийг үндэслэж, тус үеийн гэрийн үеийн бичмэлүүдийг ашиглаж, судалсан тал хараахан гүйцэт биш байсаар байна (13). Доор Хорчин зүүн гарын хойд хошууны ван, гүнгийн удам угсаанд холбогдох монгол түүхэн бичгүүд “*Илтгэл шастир*”, “*Чингийн магад хууль*” зэрэг ба гэрийн үеийн бичмэлийн хамаа бүхий тэмдэглэлийг үндэслэн, эмхэтгэн шүүж, эрхэмлэн тэмдэглэе.

Хорчин зүүн гарын хойд хошууны ван гүнгийн удам угсааны бичиг

Нэгдүгээр үе: Мянган Дархан баатар ноён (Хавт Хасарын арван долдугаар үеийн хойч)

Хоёрдугаар үе: Мянган Дархан баатар ноёноос улсын түшээ гүн Донхор Илдэч ноён, Тахар Хатанбаатар ноён, Дорж Илдэн ноён тэргүүн зэрэг тайж Санхарзай чин баатар ноён, тэргүүн зэрэг тайж Соном Дайчин ноён, тэргүүн тайж Онх Бөх ноён, дэд тайж Чандаху Эрих ноён, Санжаа Номч ноён, Бадам Цөхөр ноён үргүй, Хан Мэргэн ноён үргүй, дэд тайж Бахул Номч ноён, зэрэг олгоогүй Сэргэлэн ноён үргүй, гутгаар тайж өвгөн ноён.

Гуравдугаар үе: Донхор Илдэчээс Мада Дархан ноён үргүй, засгийн төрийн жүн ван Зангилан.

Тахар Хадан баатраас Хөмсхий,
Дорж Илдэнээс Галт,
Санхарзай Чин баатраас Доно,
Соном Дайчинаас Бутшир,
Онх Бөхөөс Ламсхий,
Чандаху Эригээс Цэрэн,
Санжаа номчоос Жаргалан,
Бахул номчоос Сун Тан,
Өвгөнөөс Бандиша.

Дөрөвдүгээр үе: Зангилангаас засаг төрийн жүн ван Бунтар, туслагч тайж Молонтой, тайж Лайсаа.

Хөмсгийгөөс Ялгуулсан,
Галтаас Гэндэн-тэн,
Доноос Ладай номч-тон,

Бодширээс Ринчин-тэн,
Ламасхийгээс Чойжав-тан,
Сэрэнгээс Бамба-тан,
Жаргалангаас Дабуу,
Бандисагаас Эрдэнэ, Цэцэн хоёр.

Тавдугаар үе: Бутаригаас засгийн төрийн жүн ван Жагар.

Ялгуулсанаас Номунсан.

Зургадугаар үе: Жагараас засаг төрийн жүн ван Тайбу, туслагч дэд сайд нар үгүй.

Долдугаар үе: Тайбугаас засаг төрийн жүн ван Равдан, засаг төрийн жүн ван Лувсанраш, туслагч Дамар, тайж Амарлингуй, тайж Данжин, тайж Даржаа.

Наймдугаар үе: Равдангаас хошууны бэйс хошой эфү Сэвдэндорж. Лувсанрашаас шадарт явсан тогосын отогт шагнагдсан чуулганы тэргүүн, засгийн төрийн жүн ван хошой эфү зургаан зэрэг тэмдэглэсэн Чимэддорж үргүй, Чан чин мөнд явсан тогосын отго шагнагдсан засгийн төрийн жүн ван Сэвдэнбалжир.

Тайжаас дэд тайж Аюурбунь, дөтгөөр тайж Бишээ, Балсан, Сацаг, Минчор, дөтгөөр тайж Бадрангуй, Бух үргүй, дөтгөөр тайж Ёндонсамбуу, дөтгөөр тайж Саяанранбуу, дөтгөөр сайд Цэвэгжав.

Есдүгээр үе: Сэвдэндоржоос Гэгээгийн хөвгүүн Чан чин мөнд явсан улсын түшээ гүн Сономцэрэн, гутгаар тайж Цэвээнноров, хоёрдугаар тайж Лаван, дөтгөөр тайж Гэмбэлдорж.

Сэвдэнбалжираас зэрэг олоогүй Цэнгүүнжав үргүй, зэрэг олоогүй Цэвээн үргүй, зэрэг олоогүй Яашжамц үргүй, шадарт явсан тогосын отго шагнагдсан чин вангийн зэрэг засгийн төрийн жүн ван хошой эфү хоёр зэрэг нэмсэн долоон зэрэг тэмдэглэсэн Содномдовж.

Цэвээнжаваас зэрэг олоогүй Баяжих үргүй, дөтгөөр тайж Санжаа, тойн банди, зарлигаар нэхэж бэйс өргөмжилсөн хоёр зэрэг тэмдэглэгдсэн Бэхи (14).

Аравдугаар үе: Сономцэрэнгээс улсад туслагч гүн Бүрэн (15), зэрэг олоогүй Зүрх үргүй.

Содномдоржоос ахмад хөвгүүн зарлигаар нэр шагнагдсан Уртхишигт үргүй, зарлигаар тэжээсэн шадар сайд засгийн жүн ван Сэнгэринчин.

Бэхис дөтгөөр зэргийн тайж хоёр зэрэг нэмсэн Намхайринчин (16) цэрэгт хүч барьсан гавьяат зарлигаар улсад туслагч гүн тогосын отго шагнагдсан нэмсэн зэрэг тав, тэмдэглэсэн зэрэг тав олгожухуй. Хоёрдугаар дүү Сэнгэринчинийг ван Содномдоржид үр болгожээ. Тогосын отог шагнагдсан нэгэн зэрэг нэмсэн Чүнгэринчин, тойн Чүнгэгарах.

Арван нэгдүгээр үе: Намхайринчингээс улсад туслагч гүн Буянбаригч, шадарт явсан тогосын отго шагнагдсан улсад туслагч гүн дөрвөн зэрэг тэмдэглэсэн Буяндүүрэгч үргүй.

Цөнхринчинээс туслагч тайж Буяндалай, тайж Буянсахигч, Буян-Орших, хутагт лам Буянчуулган.

Сэнгэринчингээс шадар сайд тогосын отго шагнагдсан засгийн Бодлогот чин ван хошой эфү есөн зэрэг нэмсэн таван зэрэг тэмдэглэсэн Буяннэмэх.

Арван хоёрдугаар үе: Буяннэмэхээс шадарт явсан тогосын отго шагнагдсан нэхэж Чин ван өргөмжлөөд таван зэрэг нэмсэн Нарс, шадарт явсан төрийн бэйл зургаан зэрэг нэмсэн Үндэс, шадар сайд улсын туслагч гүн хоёр зэрэг нэмсэн дөрвөн зэрэг тэмдэглэсэн Бодис, дэд зэрэг тайж Улиас.

Арван гуравдугаар үе: Буянбаригчаас Насантогтох тайж, улсад туслах гүн Насан-Арвижих.

Нарсаас улсын хошой Бодлогот чин ван дөрвөн зэрэг тэмдэглэсэн Амарлингуй. Аминсахигч үргүй. Зарлигаар тэжээсэн төрийн бэйл дөрвөн зэрэг тэмдэглэсэн Алтан-Очирыг төрийн бэйл болгожээ.

Үндэсээс Алтанбилигт.

Бодисоос Алтан-Очирыг Нарс ванд үрчлэв. Алтанбаатар, Алтанбагана (19), Алтанхуягт (20).

Үйлсээс Алтан-Өлзий.

Арван дөрөвдүгээр үе: Амарлингуйгаас Хишиг гүн.

Насан-Арвижихаас Бат-Алтаночир бэйс, Бадман Алтанхуягт (21).

Дээр “Алтан хүрдэн мянган хигээст”, “Илтгэл шастир”, “Гүймөнх Тасхар ноёны гэрийн үеийн бичмэл”, “Бодлогот чин ван Амарлингуйн хошууны гэрийн үеийн зураг” зэрэг түүхэн сурвалжид тэмдэглэсэн Хорчин зүүн гаран хойд хошууны ван гүнгийн удам угсааг танилцуулан, харьцуулж судалсны сууринд, эдгээр түүхэн сурвалжийн давуулаг талыг нь нотолж, хүрэлцэхгүй талыг нь нөхвөрлөн, ташаа зүйлсийг нь залруулж, Мянган Дархан ноёноос доош арван дөрөвдүгээр үе Хишиг гүн хүртэлх удам угсааг эмхэтгэн шүүж, эмхлэн тэмдэглэсэн байна.

Ерөнхийд нь дүгнэж хэлбэл, Хорчин зүүн гарын хойд хошууны ван, гүнгийн удам угсааны хувьд авч үзвэл “Алтан хүрдэн мянган хигээст” зэрэг монгол түүхэн бичигт, Умард Юань улсын сүүлч, Чин улсын эхэн үеийн монгол язгууртнуудын удам угсааг нарийн тэмдэглэсэн нь бусад хамаа бүхий хятад түүхэн бичиг хийгээд одоо олдож бүхий гэрийн үеийн бичмэлийн дутагдалтай талыг нөхвөрлөж чадна. “Илтгэл шастир” зэрэг Чин улсын албанаас найруулсан түүхэн бичигт улс төрийн шаардлагаас болж, ван, гүн, бэйл, бэйс зэрэг зэрэг хэргэм залгамжилсан удаа дараа, залгамжилсан цаг, нас нөгчсөн он зэргийг голчлон товойлгон тэмдэглэж, удам угсааны бичгийн хувьд, агуулгын талаар өрөөсгөл болсноор барахгүй, эндүү ташаа зүйл зонхи харагдана. “Бодлогот чин ван Амарлингуйн хошууны гэрийн үеийн зураг”-т Мянган Дархан баатар ноёноос Амарлингуй Чин ван хүртэлх удам угсааг нарийн тэмдэглэсэн нь “Илтгэл шастир” зэрэг түүхэн бичгүүдийн хүрэлцэхгүй талыг нөхвөрлөж, ташаа зүйлсийг залруулж чадна. Иймээс Чин улсын үеийн эл Монгол хошууны ван, гүнгийн удам угсааны бичгийг эмхэтгэн судлахад, тухайн үеийн монгол түүхэн бичиг хийгээд одоо олдож байгаа ван, гүнгийн гэрийн үеийн бичмэлүүдийг ашиглаж лавлах нь туйлын чухал юм.

Эшлэл:

1. 大清会典则例. 卷140, • 理藩院则例 • 谱系, 影印文渊阁四库全书, 第624册, 409页。
2. *Дундад улсын эртний монгол ном бичгийн ерөнхий гарчиг*. Доод. Бээжингийн номын сангийн хэвлэлийн хороо, 1532-1564.
3. 玉芝: 蒙元东道诸王及其后裔所属部众历史研究, 内蒙古大学博士论文, 2006年, 第42页。
4. Дарма. *Алтан хурдэн мянган хигээст*. Цоож тулган харьцуулж тайлбарлав. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1985, 256.
5. Рашпунцаг. *Болор эрх*. Хөх-Өндөр харгуулан тулгав. Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо, 1985, 434.
6. *Зарлигаар Тогтоосон Гадаад Монгол Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир*. Боржгин Мөнгөндалай харгуулан тайлбарлав. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2006.
7. (8), (9). *Чин улсын түүхийн эх ноорог (Qing ulus-ün teüken nooraγ)*. 166 дугаар ботийн 66 дугаар хүснэгтийн 6 дугаар нүүр.
10. *Чин улсын магад хууль*. 404 дүгээр ботийн намтрын 191.
11. Бай Ладугэчи. Сэн Гэлинкин овгийн дэлхийн жагсаалтын “Чин гүрний түүх – Фэнүүдийн тэнхимийн дэлхийн жагсаалт 1”-ийн засвар. *Өвөр Монголын их сургуулийн сэтгүүл* (Жэли нийгмийн шинжлэх ухааны хэвлэл), 1986 он, хоёр дахь дугаар. Бай Ладугэки. Сэн Гэлинкин болон бусад Монголын ноёдын төрсөн он сар өдөр: Мөн эртний монголчуудын хориотой төрсөн өдрийн зан заншлын тухай өгүүлсэн нь. Төвийн үндэстний их сургуулийн сэтгүүл. 2003 оны 5-р дугаар; Ду Жиажиг. Монголын хунтайж Сэнгэринчиний (僧格林沁) овог ба Чин хааны гэр бүлийн үеийн улс төрийн гэрлэлтийн талаарх судалгаа. Түүхийн архив. 2013 оны 1-р хугацаа; Жуо Бохай. Сэнгэринчиний асуудлын судалгаа. Хятадын Минзу их сургуулийн докторын зэрэг. 2012, 22-24-р тал.
12. *Хорчин зүүн жигүүрийн арын тугийн бичиг, түүхийн материал*. Хоёр дахь цуврал. Хорчин зүүн жигүүрийн арын туг хэвлэх үйлдвэр, 1986, хуудас 8-104.
13. *Ханхүүгийн удмын бичгийн хавсралт*. Хорчингийн зүүн жигүүрийн арын тугийн бичиг, түүхийн материал. Хоёр дахь цуврал. Хорчин зүүн жигүүрийн арын туг хэвлэх үйлдвэр, 1986 он. Гао Вэндэ, Цай Жичүн (高文德, 蔡志纯) гэх мэт. *Өвөр Монголын Хорчин овгийн удам угсаа. Монголын удам угсаа*. Хятадын Нийгмийн шинжлэх ухааны хэвлэл, 1979 он.
14. *Хорчин зүүн гарын хойд хошууны Уулын вангийн хойчис*. Сэн вангийн үе залгамжийн бичиг). 1989 онд Сэнгэринчиний их авгын хойчис Сэргэлэн хятадаар эмхэтгэсэн байна. Одоо Жаргаланд хадгалагдаж байна. Зохиогч Ар Хорчин хошууны ван гүнгийн гэрийн үеийн бичмэлийг цуглуулж байгаа Санжаа настнаас дамаар олжээ. Тус бичиг нь бүгд АЗ хуудсаар нэг нүүр байж, Сэнгэринчиний овгийн үеэс эхлэн доош тэмдэглэсэн байна. Үүнд, Сэнгэринчиний овгийн нэр, эцгийн нэр, авга нарын нэр нь бүр бусад гэрийн

үеийн бичмэлтэй адил бус. Үүнд, Сэнгэринчиний өвөг Цэвээнжавыг Дай Лай гэж, түүнд гурван хөвгүүнтэй, төдий Бөх-Очир, Бөхдэлгэр, Бөхтөмөр (Ханмута лам). Бөх-Очир нь *“Бодлогот чин ван Амарлингуйн хошууны гэрийн үеийн зураг”*-ийн тэмдэглэсэн Цэвээнжавын хөвгүүдийн доторх Санжааг зааж байх боломжтой. Бөхдэлгэр нь Бэхи, Бөхтөмөр нь Тойн Бандийг хэлж байх боломжтой. Бас Бөх-Очирын хоёр хөвгүүн Гомборинчин, Дамбаринчин гэж, Гомборинчиний хөвгүүн нь Сайн-Арвижих, Дамбаринчиний хөвгүүн Сайн-Ундрах гэж бий. Ямар түүхэн сурвалж ашигласнаа дурдсангүй.

15. Сономцэрэний хөвгүүн Бүрэнийг *“Зарлигаар Тогтоосон Гадаад Монгол Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир”* (Илтгэлийн тэргүүн, шастир арван долоодугаар)-д Насанбат гэж бий.
16. Бэхийн ахмад хөвгүүн Намхайринчинийг *“Зарлигаар Тогтоосон Гадаад Монгол Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир”* (Илтгэлийн тэргүүн, шастир арван долоодугаар.), *“Чингийн түүхийн ноорог”* (Боть 204, Боть 49)-т Ланбууринчин гэж бий.
17. Бэхийн хөвгүүдийг *“Хорчин зүүн гарын хойд хошууны Уулын вангийн хойчис”* (Сэн вангийн үе залгамжийн бичиг)-т Ланбууринчин, Чүнхаринчин, Олборинчин, Да лам, Сэнгэринчин гэж тэмдэглэжээ.
18. (19), (20), (21) *“Хорчин зүүн гарын хойд хошууны Уулын вангийн хойчис”*. (Сэ вангийн үе залгамжийн бичиг)-ээс нэмжээ.